



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭЭДЭЭ

№248 /457/

2022.01.17

Цаг үе, үйл явдал

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДАХ АЖИЛТНУУДАЙ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлага, Хэвлэл мэдээллийн албанаас Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, монголын радио, телевиз, сонин, сэтгүүл, цахим мэдээллийн мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудтай хийх уулзалтыг 3 дахь жилдээ уламжлал болгон зохион байгууллаа.

Энэхүү уулзалтад Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Ерөнхийлөгч Ө.Отгонбаатар, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөлийн гишүүд, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн удирдах зөвлөлийн гишүүд, Монголын радио, телевиз, сонин, сэтгүүл, цахим мэдээллийн мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдах албан тушаалтнууд оролцсон юм.

Уулзалтын эхэнд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба мандчилгээ дэвшүүлж хэлсэн үгэндээ "Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэргийн албаны нэр хүндийг өсгөх, нийт бие бүрэлдэхүүн болоод энхийг сахиулагчдын гавьяа зүтгэл, идэвх, оролцоо, улс орны стратегийн ач холбогдолтой бүтээн байгуулалтад жинтэй хувь нэмэр оруулж буй цэргийн алба хаагчдын бүтээлч үйл ажиллагааг шуурхай сурвалжлан мэдээлэх, түгээх ажилд цаг ямагт хамтран ажиллаж ирсэн хэвлэл мэдээллийн мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах ажилтнууд та бүхэнтэйгээ 3 дахь жилдээ уламжлал болгон уулзаж байгаадаа баяртай байна. Улс оронд болон дэлхий нийтэд өрнөж буй онцлох үйл явдлууд, нийгмийн хөгжил, иргэдийн амьдралд гарч байгаа хөгжил дэвшил, санал, санаачилга, амжилт ололт, алдаа дутагдал, аливаа гаж үзэгдлийг шүүн тунгаах, шуурхай мэдээлж, өргөн хэлэлцүүлгийг өрнүүлэн, телевиз, радио, сонин, сэтгүүл, мэдээллийн сайтуудын нийтлэлийн бодлогоор дамжуулан нийгэм, бие хүнийг зөв ирээдүйд чиглүүлэх, урилан залах нэн чухал хөдөлгөөр, хөтөлгөч хүч нь төдийгүй нийгмийн толь нь болсон хэвлэл мэдээллийн байгууллагуудын гүйцэтгэж буй үүрэг, оролцоо асар их билээ. Энэхүү бүтээлч үйл ажиллагаанд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Монголын радио, телевиз, сонин, сэтгүүл, мэдээллийн сайтуудын мэргэжлийн холбоод болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагууд Та бүхний үүрэг, оролцоо, асар их гэдгийг энд онцлохыг хүсэж байна. Зэвсэгт хүчний удирдлага, нийт бие бүрэлдэхүүн Монгол Улсын иргэд, хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч, үндэсний бахархалт үзлийг төлөвшүүлэх, улс орноо Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй сурталчлах замаар иргэн-цэргийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх зорилтыг агуулан дөрөв дэх засаглал болсон хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, сурвалжлагч нар, уран бүтээлчидтэйгээ хөгжил дэвшлийнхээ үе шат бүхэнд цаг ямагт, нягт хамтран байнгын харилцаатай ажилласаар ирлээ" гэдгийг онцлолоо.

Тэрээр цааш нь "Энд дахин тодотгоход, Зэвсэгт хүчин нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах үндсэн чиг үүрэгтэй төрийн байгууллага болохыг Та бүхэн сайтар мэдэж байгаа. Тиймээс Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний талаарх мэдээллийг төрийн хууль тогтоомжид заасны дагуу албан ёсны эх сурвалжийг нь үндэслэн түгээх шаардлага тавигддаг. Иймд Зэвсэгт хүчний талаарх аливаа мэдээлэл нь байгууллагын нэр хүндийг унагах, цэргийн албаны үнэлэмжийг бууруулах, нийт бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтворгүй байдлыг бий болгох сөрөг нөлөөтэй бөгөөд Та бүхэн бидний үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг зөвхөн албан ёсны эх сурвалжаас нь тодруулга авч, олон нийтэд түгээж байхыг хүсэж байна" хэмээв.

Үүний дараа Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч Ө.Отгонбаатар "Энэ оны 3 дугаар сард Монгол Улсад үндэсний сэтгүүл зүй үүсэж хөгжсөний 110 жилийн ойг бид ёслол тэмдэглэнэ. Өчигдөр Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл маань 72 нас хүрлээ. Та бүхэндээ баярын мэнд дэвшүүлж, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл Зэвсэгт хүчний Жанжин штабын Хэвлэл мэдээллийн албатай нягт хамтран ажилладаг. Сэтгүүлчид та бүхэн ч мэдээлэл солилцож, Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр байнга хамтарч ажиллаж буй нь мэдрэгддэг. ЗХЖШ-ын бүтэцд Хэвлэл мэдээллийн алба байгуулагдсанаас хойших хугацаанд гурав дахь жилдээ үйл ажиллагаагаа өргөжүүлэн, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг ил тод, шуурхай мэдээлэх, сурталчлах чиглэлээр олон тал

ажлыг амжилттай хэрэгжүүлж буйд талархал илэрхийлж, амжилт хүсье. Цаашид Зэвсэгт хүчний анги, салбарт хүрч, нийт бие бүрэлдэхүүний нэн ялангуяа цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд харуулах чиглэлээр санаачилга гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна" гэдгийг онцлолоо.

Мөн энэ үеэр Зэвсэгт хүчинд 2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр мэдээлэл хийсний дараа ЗХЖШ-ын Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр өнгөрсөн онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажилласан дүнг гаргасан юм. Дараа нь Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар МСНЭ-ийг "Зэвсэгт хүчинд ээлтэй шилдэг байгууллага"-аар, Монголын үндэсний олон нийтийн телевиз, "1-р суваг", "25 дугаар суваг", ТВ5, UBS, Eagle news телевизийн хамт олныг "Зэвсэгт хүчинд ээлтэй шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага"-аар шалгаруулж, "Өргөмжлөл" хүртээв. Мөн ЗХЖШ-ын даргын тушаалаар МСНЭ-ийн зөвлөх Д.Сайнбаяр, Монголын сайтуудын холбооны Ерөнхийлөгч Э.Батхүү, Монголын үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгч Б.Мөнхдел, "Монголын шилдэг нийтлэл" эрдэм шинжилгээ, судалгааны төвийн удирдах зөвлөлийн дарга, Соёлын гавьяат зүтгэлтэн Т.Баасанхүү, Eagle news телевизийн сурвалжлагч Б.Амарбаян, зураглаач Л.Очирхүү нарын шилдэг ажилтнуудыг ЗХЖШ-ын "Жуух бичиг"-ээр шагнаж урамшууллаа.

Төгсгөлд нь Цэргийн дуу бүжгийн эрдмийнчуулгын уран бүтээлчдийн шинэ уран бүтээлүүдээс бүрдсэн хүндэтгэлийн тоглолтыг үзүүлж, ажил хэрэгч ярилцлага өрнүүлэв. **Хурандаа Б.ОТГОНБАЯР**

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-16	-27

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.477	3.485
EUR	3.780	3.798
CNY	512.50	516.50
RUB	49.20	50
JPY	27.20	27.35
KRW	2.83	2.88

ЗУРХАЙ



ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Нүд бүрэлзэн улцайна
Наран ургах, шингэх:
08.36-17.28
Барилдлага:
Түлэх
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД


Тохиолдол
Нийт: 671,751,193

Эдгэрсэн
Нийт: 643,108,806

Нас барсан
Нийт: 6,732,532

Ярилцлага

БАЙЛДАГЧ А.АМАР ЦЭРГИЙН АЛБАНААС ДИПЛОМЫН АЖЛАА АМЖИЛТТАЙ ХАМГААЛЛАА



Зэвсэгт хүчинд хугацаат цэргийн алба хаангаа их, дээд сургуульдаа цахимаар суралцах, элсэлтийн болон төрийн албаны шалгалтад бэлтгэх, гадаадын их сургуулийн тэтгэлэгт өрсөлдөх зэрэг олон боломж байдгийг 2022 оны намар халагдсан зарим түүрүүч, байлдагч нар өөрсдөөрөө нотлон харуулсан билээ.

Он гарсаар үүний түүчээг Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Агиймаагийн Амар үргэлжлүүлж, саяхан дипломын ажлаа хамгаалж чадсан байна.

Энэ талаар ярихдаа "Би Улаанбаатар хотын

Чингэлтэй дүүргийнх. Эхээс дөрвүүлээ, айлын бага. Ээж минь хувиараа хөдөлмөр эрхэлдэг ажилсаг хөдөлмөрч, сайхан сэтгэлтэй Агиймаа гэдэг эмэгтэй бий. Би Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд 2015-2017 онд "АБУКА" барилгын технологийн коллежид 2.5 жилээр суралцсан. Ингэхдээ ШУТИС-ийн Эрчим хүчний сургуульд цахилгаан хангамжийн инженер мэргэжлээр давхар суралцсан. Коллежоо төгсөж чадсан ч их сургуулиа гачигдлын улмаас төгсөж чадалгүй 2017, 2018 онуудад чөлөө авсан. 2019 оноос эргэж суралцаж байгаад дөрөвдүгээр дамжаанд ордог жилдээ буюу өнгөрсөн намар цэргийн албанд татагдан ирсэн юм. Их сургуулиа төгсөх гэж бараг 7 жил зарцуулж байгаа надад хугацаа алдах эрх байгаагүй ч цэргийн албыг биеэр хаах нь миний нэгдүгээр зорилго байсан. Ийм ч учраас өнөөдөр би олон найз нөхөдтэй болж, эх орныхоо өмнө "Байлдагч би" гээд омог бардам ёслоод зогсож байна.

Аз тохиож цэрэгт ирсний дараа "Хэрэв их, дээд сургууль нь зөвшөөрвөл цахимаар суралцах боломжийг нь хангаж өгнө" гэдгийг сонсоод ээжийгээ сургуулийнхаа Н.Ихзориг багштай

уулзуулж, захидал хүргүүлсэн. Захидалдаа "Багш аа, эр цэргийн албанаас танд мэнд уламжилж байна" гээд цэргийн албаныхаа онцлогийг дурдаад ангийнхантайгаа цуг төгсөх сөн. Дипломын ажлаа хамгаалах сан гэдгээ учирласан. Багш ч зөвшөөрч, цахимаар зарим хичээлээ зааж, дипломын бүрдлийн талаар зааварчилгаа өгсөн.

Цэргийн сургалт бэлтгэлийн бус цагаар дипломын ажлаа бичиж бэлэн болгоод 1 дүгээр сарын 4-ний өдөр сургууль дээр ангийнхантайгаа хамт хамгаалсан. Одоо дипломоо 1 дүгээр сарын 24-ний өдөр гардан авна" гэв. Байлдагчийн дипломын сэдэв нь "Хотхоны цахилгаан хангамж" бөгөөд 15 давхар 4 блок орон сууц, 6 давхар үйлчилгээний төвийн цахилгаан хангамжийг нарийвчлалтайгаар дипломын ажилдаа дурджээ.

Тэрээр удаан хугацаанд төгсөж чадахгүй байсан их сургуулиа цэргийн албанд ирээд дүүргэсэндээ талархалтай байгаагаа онцолж, төгсөлтийн баяртаа цэргийн дүрэмт хувцас, байлдагчийн мөрдсөөрөө гоёж, дипломоо гардан авахаар төлөвлөснөө баяртайгаар өгүүлээ. **Ахмад Д.БОЛОР**

Цахим шууданд

ОФИЦЕРЫН ГЭРГИЙ, АЛАГ ҮРСИЙН ИЖИЙД АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ!



Зэвсэгт хүчний мөрдэс нэгт нөхөд та бидний итгэлийн гал, сэтгэлийн тусламж мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байгаа офицерт минь юу юунаас илүү хэрэгтэй боллоо. Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, дэд хурандаа Д.Батсайханы гэргий Н.Эрдэнэцэцэг маш ховор тохиолдлын нарийн гэдэсний хавдартай хэмээн оношлогдож, Монгол Улсад бүртгэгдээгүй өвчин тул яаралтай Бүгд Найрамдах Турк Улсад эмчилгээ, хагалгаа хийлгэх шаардлагатай боллоо. Албандаа итгэл дүүрэн, гэр бүл нь элэг бүтэн, үр хүүхдүүд нь ээжтэйгээ аз жаргалтай энх тунх амьдрахад тангараг нэгт та бидний сайхан сэтгэлийн тусламж, дэмжлэг одоо л хамгаас чухал байна. Дэд хурандаа Д.Батсайханы гэргий Н.Эрдэнэцэцэгийн эмчилгээнд 130-150 сая төгрөг шаардлагатай

байгаа тул офицерынхоо гэр бүлд төрийн цэргийн байгууллагууд анги хамт олон, найз нөхдөрөө сэтгэлийн хандив өргөж, эрүүл энх амьдрал бэлэглэхийг уриалж байна. Ядрахад түшээд авах нөхөд, дэмжээд босгох хамт олон гэж байдгийг харуулж, дөрвөн сайхан үр хүүхдийнх нь ирээдүйн төлөө хамтдаа тусалъя.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!
ХАРИЛЦАХ УТАС: 86117527, 99823846
ДАНС: Н. Эрдэнэцэцэг (Хаан банк 5630498525), (Капитрон банк 3022007812)
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ



МӨРДЭС НЭГТ НӨХРИЙНХӨӨ ГЭРГИЙГ МӨРӨӨС НЬ ТҮШЭЭД БОСГОЁ БҮГДЭЭРЭЭ!



2021 оны хоёрдугаар сараас савны хорт хавдрын гуравдугаар үе гэсэн оноштойгоор шаналж буй офицерын гэргий, хоёр сайхан алаг үрийн ээжид амьдрал бэлэглэх сайн үйлсийн аяныг эхлүүлж байна. Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Сургалтын албаны дарга, хошууч П.Отгонбаатарын гэргий Д.Солонго нь савны хорт хавдрын гуравдугаар үе гэж 2021 оны хоёрдугаар сард оношлогдсоноос хойш 29 туяа эмчилгээ, 16 удаа хими эмчилгээ хийлгэсэн боловч хавдар нь бага аарцагтаа мэдрэлийн судас дарж, үсэрхийлсний улмаас хоёр хөл нь мэдээ алдаж, суугаа болоод байгаа юм. Иймд цаашдаа цаг алдалгүй хагалгаа, эмчилгээ хийлгэхгүй бол амь эрсдэх аюул ойрхон байгаа тул төрийн цэргийн байгууллагын алба хаагчид, сайхан сэтгэлд ард түмнээсээ тусламжийн гараа сунгахыг уриалж байна. Хагалгааг Бүгд Найрамдах Турк Улсын "Медиалпарк" эмнэлэгт 90 сая төгрөгийн өртэйгөөр хийхээр товллоод байгаа бөгөөд одоо гагцхүү цаг алдалгүй эмчилгээндээ орох шаардлага үүсээд байна. Үйлс зорилго нэгтэй залуу офицерынхоо аз жаргалтай гэр бүлд элэг бүтэн амьдрал бэлэглэхэд нэгдэж, хандив өргөхийг хичээнгүйлэн хүсэж байна.

Таны хийж буй буян буцаж ирэхдээ бороо мэт асгарах болтугай!
ХАРИЛЦАХ УТАС: 95038800, 89040408 **ДАНС: Д.Солонго (Хаан банк 5018163641)**
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ



Цахим шууданд

ХУРД, ХҮЧЭЭ СОРИН ӨРСӨЛДӨВ



ҮБХИС-ийн багш, сонсогч оюутнуудын дунд "Футзал"-ын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 9 багийн 60 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс нэгдүгээр байрт Багш нарын баг, хоёрдугаар байрт АБДС-ийн "Ганаа ба түүний нөхөд" баг, гуравдугаар байрт ЦНДС-ийн "4-р курс" баг тус тус шалгарсан бол шилдэг хаалгачаар төрөлд АБДС-ийн инженер механикийн тэнхимийн оюутан Б.Ган-Очир шилдгээр нэрлэгдэв.

Ахмад Д.ГАНЦЭЦЭГ

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН АЖИЛЛАХ ОРЧИН, АНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦУУЛАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч, жил болгосонтой холбогдуулан Агаарын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч 2023 цэргийн командлалаас офицеруудаа оныг "Залуу офицеруудын манлайлал"-ын дэмжих, тэдний ажил үүргийг таниулах

арга хэмжээг тасралтгүй зохион байгуулсаар байна.

Тухайлбал, энэ сарын 13-ны өдөр Агаарын цэргийн залуу офицеруудын ар гэрийн төлөөлөл, Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний 303, 337, 353 дугаар ангиудад зочлон цэргийн ангиудын өдөр тутмын үйл ажиллагаа, офицеруудын ажлын орчин, нөхцөлтэй танилцсан юм.

Уг арга хэмжээ нь залуу офицеруудын ар гэрт цэргийн алба хаагчдын ажлын онцлог, ачаалал, гүйцэтгэдэг үүрэг, мэргэжлийн ур чадвар зэрэг олон асуудлыг таниулан, ойлгуулж чадсанаараа онцлог байлаа.

АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
 Батлан хамгаалах яам
 Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
 "Соёмбо" сонин
 "Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
 * Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
 * Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
 Утас: 70001029, 3412 (дотуур)